Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцох шаардлагатай байна.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 4,329,894.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 64,948.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 38,397.2 мянган төгрөгөөр буурсан байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувиар буюу 48,711.3 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, төрийн сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Эмийн эргэлтийн сан, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан зэрэг 11 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем програмыг ашиглаж байна.

Орлогын талаар:

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн орлого 1,109,896.4 мянган төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилт 1,849,722.4 мянган төгрөг, аймгаас санхүүгийн дэмжлэг 401,369.0 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 122,575.1 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 1,851,763.7 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 13,798.1 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 261,825.4 мянган төгрөг, орон нутгийн төсөвт байгууллагуудаас төвлөрүүлсэн орлого 59,965.9 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 67,364.9 мянган төгрөг, ОНХС-аас эргэн төлөлт 7,600.0 мянган төгрөг, эргэлтийн эмийн сангийн борлуулалтын орлого 127,186.9 мянган төгрөг нийт 5,875,330.6 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг төвлөрүүлэн, зарцуулсан байна.

Эрдэнэ сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 20 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 757,793.4 мянган төгрөг, татварын бус орлогыг 65,250.0 мянган төгрөг, нийт 823,043.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсөвт 2021 онд татварын орлого 947,825.6 мянган төгрөг, татварын бус орлого 164,196.6 мянган төгрөг, нийт 1,109,896.4 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг 162,070.8 мянган төгрөг буюу 134,8 хувиар биелүүлсэн байна. Орон нутгийн орлогын төлөвлөгөө өндөр хувиар биелэхэд ойн төлбөр 79,286.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн нь самрын зөвшөөрөл олгосон, 2021 онд малын тоо толгойн татварыг сумын ИТХ тогтоож баталсантай холбоотой 66,997.1 мянган төгрөг, нэр зааж ангилагдаагүй орлого 51,695.4 мянган төгрөгөөр давж биелсэн нь газрын зориулалт өөрчлөгдсөнтэй холбоотой үнийн зөрүү, газрын төлбөр 39,465.4 мянган төгрөг, хүү торгуулийн орлого 45,375.4 мянган төгрөгөөр биелүүлсэн нь торгуулийн мэдээлэл ө баримтаар очсоноор цахим төлөлт сайжирсан зэрэг нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 375,594.0 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 267,329.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор нийт 642,923.4 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба 231,597.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 30,831.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлж данснаас хассан байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 618,992.0 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 283,068.7 мянган төгрөг, бусад 32,394.3 мянган төгрөг, нийт 934,454.9 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 885,571.4 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна.

Авлага, өглөгийн талаар:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагаас авах 182,149.3 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 315,091.5 мянган төгрөг, ажиллагчидтай холбоотой авлага 38,217.4 мянган төгрөг нийт 535,458.2 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн байна. Нийт авлагын 322,280.5 мянган төгрөг буюу 61,0 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 75,134.2 мянган төгрөг буюу 14,0 хувийг ЭМТ, 45,000.0 мянган төгрөг буюу 8,4 хувийг ЗДТГ, 38,567.6 мянган төгрөг буюу 7.2 хувийг ЕБС, 38,222.6 мянган төгрөг буюу 7,1 хувийг ОНХС -ийн авлага эзэлж байна.

Байгууллагад төлөх 36,278.5 мянган төгрөг, хувь хүмүүст төлөх 12.8 мянган төгрөг, нийт 36,291.3 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Нийт өрийн 36,053.9 мянган төгрөг буюу 99,3 хувийг ЭМТ-ийн өр эзэлж байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 299,437.6 мянган төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд 1,217.4 мянган төгрөг, нийт 300,655.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Бараа материал 315,757.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 7,836,046.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	722,677.4	460,385.5	- 262,291.9
Авлага	425,901.6	535,458.2	109,556.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	267,053.9	315,757.5	48,703.6
Нөөцийн бараа /сурах бичиг/	-	-	-
Үндсэн хөрөнгө	7,985,316.2	7,836,046.3	- 149,269.9
Нийт хөрөнгө	9,400,949.2	9,147,647.5	- 253,301.7
Өр төлбөр	14,378.5	36,291.3	21,912.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,386,570.7	9,111,356.2	- 275,214.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,400,949.2	9,147,647.5	- 253,301.7

Бараа материалын дансны үлдэгдэл 315,757.5 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 48,703.6 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материал, бусад хангамжийн материал, мал амьтад, тусгай зориулалтын материалын үлдэгдэл өмнөх оноос өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,836,046.3 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 149,269.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн үндсэн хөрөнгө нь үнэ төлбөргүй хүлээн авсан Орон нутгийн хөгжлийн сан болон 2020 оны шилжих үлдэгдлээс 679,198.6 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,111,356.2 мянган төгрөг болж 275,214.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сумын 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 4,580,631.00 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд болон хөрөнгийн зардалд зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Эрдэнэ сумын ИТХ-ын Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 20 дугаар тогтоолоор 2021 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 823,043.4 мянган төгрөгөөр, зарлагын нийт хэмжээг 3,881,559.3 мянган төгрөгөөр баталсан байна. Сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 20 дугаар тогтоолоор 2021 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 3,907,520.8

мянган төгрөгөөр тодотгон баталсан ба сум хөгжүүлэх сангийн орлогыг 120,000.0 мянган төгрөгөөр, нийт 4,027,520.8 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн захирагчийн 2021 оны төсвийн төслөөс 546,264.5 мянган төгрөгөөр бууруулан санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайланд 7 хөтөлбөр 20 арга хэмжээнд зориулан нийт 4,027,520.8 мянган төгрөг төлөвлөсөн. Энэ нь сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор батлагдсан төлөвлөгөөг нийт 4,034,206.5 мянган төгрөгөөр тайлагнасан нь ИТХ-ын батлагдсан төлөвлөгөөнөөс ЕБС 6,685.7 мянган төгрөгөөр илүү, төсөвт газрын өөрийн орлого 250.0 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй байна.

Нийт зардлын 1,851,763.7 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,849,312.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 39,805.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 122,575.1 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс, 120,000.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 3,039,703.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 637,277.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 60,232.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 3,737,212.8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 91,995.1 мянган төгрөгийг аймгийн төсөвт, 59,965.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,737,212.8 мянган төгрөг буюу 92,6 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн нэгтгэсэн тайланд 261,825.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, бараа, ажил үйлчилгээний зардалд 236,458.8 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг, урамшуулалд 25,366.7 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 2,125.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж 37.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Эрдэнэ сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС –ийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЗДТГ 4,402.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 191,033.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 5,526.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж, ИТХ 7,169.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж, СХС 159,814.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, Соёлын төв 229.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага тус тус өгөгдсөн байна.

- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Дундманхайдай аудит ХХК аудит хийж, ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв гэсэн 3 байгууллагын санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт гаргаж, эргэлтийн эмийн сангийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЕБС-ийн санхүүгийн тайланд 38,767.4 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 587.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд 240.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 7,636.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 9,284.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 1,471.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 820.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж, Эргэлтийн эмийн сан 115,216.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Эрдэнэ сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 20 дугаар тогтоолоор тодотгон баталсан 3,907,520.8 мянган төгрөгийн төсвийг Төсвийн гүйцэтгэлийн тайланд 6,845.7 мянган төгрөгөөр буюу ИТХ-ын батлагдсан төлөвлөгөөнөөс тусгай зориулалтын шилжүүлэг 6,935.7 мянган төгрөг, ЗДТГ-ын 90.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа зөрчлийг ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тодруулах шаардлагатай байна.

Аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолтыг Татварын албанаас гаргуулан цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар болон Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварын тооцооллыг тулгахад сумын ИТХ 3,665.9 мянган төгрөг, Соёлын төв 177.5 мянган төгрөг, ЭМТ 465.0 мянган төгрөг, ЕБС 15,869.1 мянган төгрөг дутуу, Цэцэрлэг 185.5 мянган төгрөг, ЗДТГ 7,532.1 мянган төгрөгөөр тус тус илүү зөрүүтэй байна. Орон нутгийн татварын орлогыг тооцооллыг тухай бүрд хийдэггүйгээс аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолтоор илүү, дутуу үлдэгдэлтэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 152 мэдээллээс хугацаа хоцроосон 32 мэдээлэл байгаа нь нийт мэдээллийн 21,0 хувийг эзэлж байна. Шилэн дансны мэдээлэлд байгууллагын даргын нэрийг солиогүй, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлээгүй, дараа жилийн төсвийн төсөлд нэгтгэсэн төслийг оруулж мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 6 зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 05/307 дугаар албан бичгээр ирүүлсэн ба СХС, ОНХС-ийн зөвлөмж бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын болон татварын бус орлогыг зөрүүтэй мэдээлж буй зөрчлийг таслан зогсоосон эсэх болон ковидын зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 349,855.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 299,531.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,601.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 33,134.0 мянган төгрөгийн албан шаардлага, 14,589.2 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Төсөвт байгууллагуудын татварын өр авлагын тодорхойлолтыг татварын цахим системээр гаргахад төсвийн нийт 6 байгууллагад 37,966.7 мянган төгрөг дутуу, 262,723.1 мянган төгрөг илүү үлдэгдэлтэй гэж тайлагнасан нь ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн татварын өр, авлагын үлдэгдэлтэй тохирохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгийн орлого 22,764.2 мянган төгрөгөөр дутуу, бараа материалын орлого 17,974.8 мянган төгрөгөөр ЗДТГ, Эмнэлэг илүү, 18,208.6 мянган төгрөгөөр ЕБС дутуу, үр дүнгийн тайланд 9,043.7 мянган төгрөгөөр үндсэн цалин, нэмэгдэл цалинг зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 20 дугаар тогтоолоор сумын татварын орлого 757,793.4 мянган төгрөг, татварын бус орлого 65,250.0 мянган төгрөг, нийт 823,043.4 мянган төгрөгөөр баталснаас орлогын гүйцэтгэлийн тайланд ТГӨО-ын батлагдсан төлөвлөгөө 250.0 мянган төгрөгөөр, ТЗШ-ын санхүүжилт 6,935.7 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2021 оны 5 дугаар сарын 19-ны өдрийн 1414001012 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 3877736 дугаарын регистртэй Эрдэнэ тохижилт үйлчилгээ ААТҮГ байгуулагдсаныг нэгтгэсэн тайланд нэгтгэгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Мал хамгаалах сан хаагдсан байхад 2,601.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2-д “өр, авлага үүсгэхгүй байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

4.3 Албан шаардлага

Орон нутгийн төлөвлөсөн орлогоос иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого 5,261.7 мянган төгрөгөөр буюу 21,9 хувиар, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар 1,777.0 мянган төгрөг буюу 16,2 хувиар, ус ашигласны төлбөр 22,233.1 мянган төгрөг буюу 63,5 хувиар, хог хаягдлын хураамж 3,862.6 мянган төгрөг буюу 14,0 хувиар, нийт 4 нэр төрлийн татварын орлого 33,134.4 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "оршин байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МҮЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй" бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой

1.1. Илрүүлэлт:

Татварын хэлтсийн мэдээ нь татварын улсын байцаагчийн аудитад ирүүлсэн мэдээ тайлангаас 7,743.5 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д "Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Холбогдох байгууллага, албан тушаалтан төсвийн мэдээллийн тогтолцоонд үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь оруулах, мэдээллийн үндсэн баримтыг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах үүрэгтэй" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын болон татварын бус орлогыг мэдээлэхдээ орлогын дансны хуулгыг боловсруулан үнэн зөв мэдээлж байх ба түүнд тавих хяналтыг сайжруулах

1.2. Илрүүлэлт:

Сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 20 дугаар тогтоолоор татварын орлого 757,793.4 мянган төгрөг, татварын бус орлого 65,250.0 мянган төгрөг, нийт 823,043.4 мянган төгрөгөөр баталсан. Орлогын гүйцэтгэлийн тайланд ТГӨО-ын батлагдсан төлөвлөгөө 250.0 мянган төгрөгөөр, ТЗШ-ийн санхүүжилт 6,935.7 мянган төгрөгөөр илүү нэгтгэгдсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" гэсэн заалт болон

санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын жилийн төсвийн сар, улирлын хуваарийг баталж мөрдүүлэхдээ сумын ИТХ-аас баталж ирүүлсэн тогтоолын тоо, дүн зөрүүтэй алдааг засуулж авах бөгөөд тогтоол нь төлөвлөгөөнөөс зөрүүтэй байсан зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой

2.1. Илрүүлэлт:

Эрсдэлтэй асуудал болох төсөвт байгууллагуудын дотоод хяналт хэрэгжиж байгаа эсэх, цахим төлбөрийн баримтаар гүйлгээ хийгдэж байгаа эсэх, татварын өр авлагын тодорхойлолттой санхүүгийн тайланд дахь өр авлага тохирсон эсэх, шилэн дансны мэдээллийг үнэн зөв, ойлгомжтой, бүрэн мэдээлсэн эсэх зэрэг асуудлаар хяналт шалгалт хийгдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-д “дотоод аудит гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг гэж ойлгоно”, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1-д “Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн өөрийн болон доод шатны Засаг даргын ажлын алба, харьяа байгууллага, аж ахуйн нэгжид дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж мөрдүүлэх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлж ажиллах

2.2. Илрүүлэлт:

Шилэн дансны мэдээлэлд байгууллагын даргын нэрийг солиогүй, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлээгүй, дараа жилийн төсвийн төсөлд нэгтгэсэн төслийг оруулж мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд төсвийн төсөл болон төсвийн гүйцэтгэлийн хэмнэлтийн тайлбар шалтгааныг ойлгомжтой мэдээлж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс								Дүгнэлтийн хэлбэр
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	
1	Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга	10	349,855.6	4	299,531.4	1	2,601.0	1	33,134.0	4	14,589.2	Зөрчилгүй
ТТЗ-ийн дүн		10	349,855.6	4	299,531.4	1	2,601.0	1	33,134.0	4	14,589.2	
2	Эрдэнэ сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	7,169.1	0	0	0	0	1	7,169.1	0	0	Түүвэр
3	Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар	5	207,362.3	1	6,400.0	1	4,402.0	1	191,033.6	2	5,526.7	Зөрчилгүй
4	Эрдэнэ сумын Соёлын төв	1	229.3	0	0	0	0	1	229.3	0	0	Түүвэр
5	Эрдэнэ сумын Хүн эмнэлэг	5	2,291.7	0	0	1	1,471.2	1	0	3	820.5	Зөрчилгүй
6	Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль	6	47,730.5	1	8,376.1	2	550.0	1	38,217.4	2	587.0	Зөрчилгүй
7	Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэг	6	17,160.9	0	0	1	240.0	2	7,636.8	3	9,284.1	Зөрчилгүй
ТШЗ-ийн дүн		24	281,943.8	2	14,776.1	5	6,663.3	7	244,286.1	10	16,218.3	
8	Эрдэнэ сумын ОНХС	-	-	0	0	0	0	0	0	0	0	Түүвэр
9	Эрдэнэ сумын Сум хөгжүүлэх сан	1	159,814.5	0	0	0	0	1	159,814.5	0	0	Түүвэр
10	Эрдэнэ сумын Эргэлтийн эмийн сан	3	115,216.9	0	0	0	0	0	0	3	115,216.9	Түүвэр
ОНТС-ийн дүн		4	275,031.4	-	-	-	-	1	159,814.5	3	115,216.9	
Нийт дүн		38	906,830.9	6	314,307.5	6	9,264.3	9	437,234.6	17	146,024.4	